



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 8/41

Хэрлэн сум

Э.Ариунтунгалагийг үргэлжлүүлэн  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Санхүү, эдийн засгийн сайдын 2022 оны 258 дугаар тушаалаар баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Энхбаатарын Ариунтунгалаг нь хүүхэд асрах чөлөөнөөс хугацаанаас өмнө үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Э.Ариунтунгалагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	М.Дэлгэрзаяа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Чулуунцэцэг	Няравын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3.Э.Ариунтунгалагийн үндсэн цалинг ТҮ-8 зэрэглэлээр тогтоон, 1,114,000 (нэг сая нэг зуун арван дөрвөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож, олгохыг Нягтлан бодогч (Г.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

231030114

2.

4.Э.Ариунтунгалагийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (С.Нямдаваа)-д даалгасугай.

5.Э.Ариунтунгалагт нягтлан бодогчийн хөдөлмөрийн гэрээ болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА